



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 16/07

Арвайхээр сум

“Онги-Ус суваг” Орон нутгийн өмчит ХХК-ийн
Төлөөлөн удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Онги-Ус суваг” орон нутгийн өмчит ХХК-ийн дүрмийн 6.1, 7.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Онги-Ус суваг” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Ердийн гишүүд:
- Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
 - А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
 - Г.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Хөрөнгийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн)
 - Б.Очирсүрэн (Арвайхээр сумын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ӨНААТҮГ-ын нярав)
 - Б.Мөнхбат-(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтийн хэлтсийн Дэд бүтэц, бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
 - Т.Мөнхбаян (Арвайхээр сумын архитектор)
- Хараат бус гишүүд:
- П. Адъяасүрэн (Арвайхээр сумын иргэн)
 - М. Нэмэхбаяр (Арвайхээр сумын иргэн)
 - Н. Болдбаатар (Арвайхээр сумын иргэн)

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, ажлаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 77 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ